

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн тодруулга, аудитын дүн.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
3.1. Балансын данстай холбоотой асуудал.....	9
3.2. Зардалтай холбоотой асуудал.....	9
3.3. Гэрээ ажил үйлчилгээ, цалинтай холбоотой асуудал.....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	14
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	15

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА Б.БААТАРЗОРИГ ТАНАА

2020.04.24 № 1330  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгө, бараа материалыг баримтад үндэслэн үнэн зөв бүртгэх, анхан шатны баримтын бүрдлийг хангах, цалингийн зардлыг үнэн зөв тооцож байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 13-аас 2020 оны 4 дүгээр сарын 23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитор Д.Цэгмиддорж гүйцэтгэв.

Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 06/504 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе

шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

#### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Төрийн албаны зөвлөлийн эрхэм зорилго нь “Иргэдэд ойр, уян хатан, идэвхитэй, санаачилгатай бөгөөд цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн манлайлагч менежер бүхий төрийн албыг бүрдүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгыг хүрээнд дараах зорилтыг тодорхойлсон байна.

- Төрийн албаны шинэтгэлийн стратегийн баримт бичгийг шинэчлэн боловсруулж батлуулан, үйл ажиллагааныхаа мөрдлөг болгох,
- Төрийн албаны тухай хуулийн үзэл баримтлалд бусад хууль тогтоомжийг нийцүүлэх талаар судлан нэг мөр болгож зохицуулах,
- Төрийн албаны тухай хууль тогтоомжийг нийт төрийн албаны хэмжээнд дагаж мөрдөж байгаа нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, байгууллага бүр зөрчилгүй ажиллах дархлаатай болох,
- Төрийн албаны хүний нөөцийн аудитыг агуулга зорилтын дагуу хэрэгжүүлж, үр нөлөөг нь байгууллагын хөгжилд ашиглах боломжоор хангах,
- Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар төрийн албан хаагчдыг соён гэгээрүүлэх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, гарсан зөрчлийг таслан зогсоох, цаг тухайд нь шийдвэрлэх, холбогдох албан хаагчдад хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг байгууллага нэг бүрд хэвшүүлэх,
- Төрийн албан хаагчийн сургалт, хөгжилтэй холбоотой асуудлыг Төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан агуулга, хэлбэрээр нь шинэчлэн зохион байгуулах, хамтрагч байгууллагуудын хооронд зохистой хамтын ажиллагааны горим тогтоох,
- Төрийн албаны шатлан дэвших нөөцөд хамрагдах төрийн албан хаагчдын судалгааг бүрэн гаргаж, шатлан дэвшүүлэх болзол, шаардлагыг хангуулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг болох,

#### **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төрийн албаны зөвлөлийн даргын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Төрийн албаны зөвлөлийн даргын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Төрийн албаны зөвлөлийн даргын бэлтгэсэн санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн

үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг үр дүнгийн тайлангийн 1,269.1 сая төгрөгийн зардлын 2 хувь буюу 25.4 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин тооцох шаардлагагүй гэж үзлээ.

## 2.8. Аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн тодруулга, аудитын дүн

### 2.8.1 Бараа материал

Бараа материалын ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ үлдэгдэл 16.7 сая төгрөг болж өмнөх оноос 0.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төсөвт байгууллага	16.1	16.7	0.6
<b>Дүн</b>	<b>16.1</b>	<b>16.7</b>	<b>0.6</b>

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны санхүүгийн тайлан

Бараа материал эхний үлдэгдэл 16.1 сая төгрөг байснаас тайлант онд 12.5 сая төгрөгийн бараа материал худалдан авч 11.9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, 16.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### 2.8.2 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн ~~Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,320.6 тэрбум, эцсийн үлдэгдэл 4,625.7 тэрбум төгрөг болж, 305.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.~~ эхний үлдэгдэл 272.1 сая байсан бол эцсийн үлдэгдэл 415.9 сая төгрөг болж, 143.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төсөвт байгууллага	272.1	415.9	143.8
<b>Дүн</b>	<b>272.1</b>	<b>415.9</b>	<b>143.8</b>

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны санхүүгийн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 234.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна. Үүнд:

Тавилга хэрэгсэл 81.7 сая төгрөг, тоног төхөөрөмж 61.0 сая төгрөг, программ хангамж 84.0 сая төгрөг, бусад хөрөнгө 8.0 сая төгрөгөөр худалдан авсан байна.

УИХ-ын 2019 оны 07 дугаар тогтоолоор орон тоо нэмэгдсэнтэй холбоотой тус зөвлөл үндсэн хөрөнгө /ширээ, сандал, тавилга, компьютер, техник хэрэгсэл, программ/ худалдан авсан нь байна.

*Аудитын илрүүлэлт:*

- Аж ахуй нэгжүүдээс үндсэн хөрөнгө, бараа материал, худалдан авсан боловч данс бүртгэлд зөрүүтэй тусгасан, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй;
- Цаашид бараа материалын худалдан авалт хийхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах;

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,322.2 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,322.2 сая төгрөгийн санхүүжилт авч 1,314.6 сая төгрөгийг зарцуулж, 7.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,314.6 сая төгрөг буюу 99.4 хувьтай, 7.6 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна. Батлагдсан төсвийг дутуу зарцуулсан нь орон тоо дутуу ажилласантай холбоотой байна.

Батлагдсан төсвөөс эдийн засгийн ангиллаар материаллаг дүнтэй илүү, дутуу зарцуулсан дараах зардлууд байна. Үүнд: Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 7.3 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.2 сая төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

**Нэмэлт төсөв:** Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 90.9 сая төгрөгийг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнд 71.1 сая төгрөг, мэдээлэл технологийн үйлчилгээнд 4.0 сая төгрөг, хангамжийн материалд 6.5 сая төгрөг, хичээл сургалтын зардалд 5.8 сая төгрөг, тэтгэмж урамшуулалд 3.5 сая төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## 2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 8 эрсдэлтэй асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүллээ.

Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 25.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 3.7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 12.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлж 9.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Ээлжийн амралт болон цалинг давхардуулан 1.7 сая төгрөг, хөлсөөр ажиллаж буй алба хаагчдад ээлжийн амралтын 2.0 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.



2. Уулзалтын зардал, түрээсийн төлбөрт 12.1 сая төгрөгийг тушаал шийдвэр төсөвгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 9.3 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд өгсөн 3 зөвлөмжийг Менежментийн захидалд тусгалаа.

#### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад цалингийн зардалд давтан тооцоолол хийж, цагийн бүртгэл, хөлсөөр ажиллах гэрээг мөшгин шалгаж тулган баталгаажуулж амжаагүй болно.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Төрийн албаны зөвлөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 150 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/156 дугаар тушаалаар "Итгэл үзүүлсэн" байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 25.4 сая төгрөг, залруулагдаагүй алдаа зөрчлийн нийт дүн 25.1 сая төгрөг учир "Зөрчилгүй" санал дүгнэлт өгч байна.

Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Төрийн албаны зөвлөлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Аж ахуй нэгжүүдээс үндсэн хөрөнгө, бараа материал, худалдан авсан боловч данс бүртгэлд зөрүүтэй тусгасан, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй, Цаашид бараа материалын худалдан авалт хийхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх" 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.5-д "бүх орлого", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйл "Худалдан авах ажиллагааны журмыг сонгох" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Холбогдох хууль, журам заавар хэрэгжүүлээгүй байх санхүүгийн тайлангийн тоо мэдээ буруу илэрхийлэгдэх;

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Үндсэн хөрөнгө, бараа материалыг данс бүртгэлд үнэн, зөв тусгаж байх, худалдан авалт хийхдээ холбогдох хууль журмыг мөрдөж ажиллах.

##### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### **3.2 Зардалтай холбоотой асуудал**

##### **3.2.1 Илрүүлэлт:**

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 9.3 сая төгрөгийг шууд зардлаар бүртгэж зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

#### 3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, журам зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

#### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгахгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах;

#### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### 3.3 Гэрээ ажил үйлчилгээ, цалинтай холбоотой асуудал

#### 3.3.1 Илрүүлэлт:

Хөлсөөр ажиллах гэрээний үүргийг хэрэгжүүлээгүй нэг удаагийн буцалтгүй тусламж, ажлын хөлс зэргийг цалингийн зардлаас зарцуулсан, цагийн бүртгэлээр баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар" Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг зөрчсөн байна.

#### 3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн тоо мэдээ буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, журам зааврыг мөрдөж ажиллаагүй байх, төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх,

#### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэлд тусгахгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах, төсвийг бодитой тоо мэдээнд үндэслэн төлөвлөж байх;

#### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	16,138.8	16,717.7
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	16,138.8	16,717.7
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	272,098.8	415,897.9
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	272,098.8	415,897.9
<b>Биет хөрөнгө</b>	218,497.1	296,181.3
<b>Биет бус хөрөнгө</b>	53,601.6	119,716.6
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	288,237.6	432,615.6
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	288,237.6	432,615.6
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	288,237.6	432,615.6
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	434,739.6	434,739.6
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-147,371.6	-2,993.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	869.5	869.5
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	288,237.6	432,615.6

##### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	824,441.4	1,413,503.9
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	93,687.0	91,286.5
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	93,687.0	91,286.5
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	730,754.4	1,322,217.4
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	794,203.9	1,269,125.9
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	794,203.9	1,269,125.9
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	786,386.1	1,151,610.1
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	300,869.6	627,664.3
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	36,217.9	79,378.9
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,221.2	22,213.5
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	43,657.8	87,157.2
<b>Томилот, зочны зардал</b>	14,398.6	14,398.6
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	262,493.9	192,392.1
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	106,527.1	128,405.4
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	7,817.7	117,515.8
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	30,237.5	144,378.1
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	38,634.7	-
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	-8,397.1	144,378.1

#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2018оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	730,754.4	1,413,503.9
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	730,754.4	1,413,503.9
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	730,754.4	1,413,503.9
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	730,754.4	1,413,503.9
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	722,936.7	1,295,988.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	301,814.6	627,664.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,217.9	79,378.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,221.2	22,213.5
Хангамж, бараа материалын зардал	50,675.3	74,189.4
Эд хогшил, урсгал засварын зардал	-	122,207.0
Томилолт, зочны зардал	14,398.6	14,398.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	262,493.9	315,036.8
Бараа үйлчилгээний бусад зардал	35,115.2	40,899.7
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	7,817.7	117,515.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	296,634.7	-	296,634.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	296,634.7	-	296,634.7
Тайлант үеийн үр дүн	-8,397.1	-	-8,397.1
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	288,237.6	-	288,237.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	288,237.6	-	288,237.6
Тайлант үеийн үр дүн	144,378.1	-	144,378.1
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	432,615.6	-	432,615.6

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-	-	-
I Нийн зарлага болон цэвэр зээлийн дүн (II+V)	-	-	-	-
II Нийт зарлагын дүн (III+IV)	1,322,217.4	1,314,631.2	7,586.2	99.4
III Урсгал зардлын дүн	1,322,217.4	1,314,631.2	7,586.2	99.4
Бараа үйлчилгээний зардал	714,409.5	707,043.2	7,366.3	99.0
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	635,030.6	627,664.3	7,366.3	98.8
Үндсэн цалин	490,715.7	483,349.4	7,366.3	98.5
Нэмэгдэл цалин	89,126.9	89,126.9	-	100.0
Унаа, хоолны хөнгөлөлт	55,188.0	55,188.0	-	100.0
Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэл	79,378.9	79,378.9	-	100.0
Тэтгэмжийн даатгал	79,378.9	79,378.9	-	100.0
Бараа, үйлчилгээний бусад зардал	607,807.9	607,587.9	220.0	99.9
Байрны түрээс	22,221.3	22,213.5	7.8	99.9
Бичиг хэрэг	7,374.5	7,374.0	0.6	99.9
Тээвэр, шатахуун	53,800.5	53,737.3	63.2	99.9
Шуудан, холбоо	5,807.0	5,807.0	-	100.0
Дотоод албан томилолт	14,398.6	14,398.6	-	100.0
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	31,718.4	31,704.4	14.0	99.9
Эд хогшил худалдан авах	727.1	789.8	-62.7	108.6
Багаж, техник хэрэгсэл	122,220.5	122,207.0	13.5	100.0
Мэдээллийн технологийн үйлчилгээ	146,419.8	146,360.8	59.0	100.0
Биеийн тамирын уралдаан тэмцээн	3,397.7	3,397.7	-	100.0
Байр ашиглалтын үйлчилгээ	87,219.2	87,219.2	-	100.0
Мэдээлэл сурталчилгааны зардал	1,188.0	1,174.0	14.0	98.8
Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	4,851.2	4,851.2	0.0	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	277.2	177.0	100.2	63.9
Тээврийн хэрэгслийн оношилгоо	19.8	9.5	10.3	48.0
Даатгалын үйлчилгээ	118.8	118.8	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	950.0	950.0	-	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	105,098.3	105,098.3	-	100.0
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,322,217.4	1,314,631.2	7,586.2	99.4
Улсын төсвөөс санхүүжих	1,322,217.4	1,314,631.2	7,586.2	99.4
Б.Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл	-	-	-	-

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		<b>90,940.0</b>
Урсгал зардал		90,940.0
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>87,405.2</b>
<b>Хангамж бараа материалын зардал</b>		<b>6,481.4</b>
Бичиг хэргийн материал		1,499.9
Тээвэр шатахууны зардал		3,000.0
Шуудан холбооны зардал		1,981.5
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж</b>		<b>75,126.3</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж		71,128.0
Мэдээлэл технологийн үйлчилгээ		3,998.3
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>5,797.6</b>
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал		5,797.6
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>3,534.8</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>3,500.0</b>
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		3,500.0
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>34.8</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг		34.8
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>90,940.0</b>
Нэмэлт санхүүжилтийн орлого		90,940.0
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		90,940.0

**5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Д/д	Харьяа байгууллага	Аудитад хамрагдсан хэлбэр	Нийт зөрчил		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Дүгнэлт Зөрчилгүй	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>А</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>6</b>	<b>7</b>	<b>8</b>	<b>9</b>	<b>10</b>
1	Төрийн албаны зөвлөлийн дарга	1	5	25.1	1	3.7	1	12.1	3	9.3
	<b>ДҮН</b>	<b>1</b>	<b>5</b>	<b>25.1</b>	<b>1</b>	<b>3.7</b>	<b>1</b>	<b>12.1</b>	<b>3</b>	<b>9.3</b>





## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2020 оны 04 дугаар сарын 24

№ 01/93

Улаанбаатар хот

САГ- 20 20/16/СТА-ТЭЗ

### Орлого төвлөрүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасан цаглабарт хугацаанд хийсэн Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ээлжийн амралт болон цалинг давхардуулан 1.7 сая төгрөг, хөлсөөр ажиллаж буй алба хаагчдад ээлжийн амралтын 2.0 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ээлжийн амралт болон цалинг давхардуулсан, хөлсөөр ажиллаж буй алба хаагчдад ээлжийн амралт олгосон 3,660,488.0 /гурван сая зургаан зуун жаран мянга дөрвөн зуун наян найман/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь 100900000601 тоот дансанд 2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх.
2. Биелэлтийг 2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Санжрагчаа, Ерөнхий нягтлан бодогч Н.Болортуяа нарт хариуцуулав.

**ТОГТООСОН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР *[Signature]* Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТОР *[Signature]* Д.ЦЭГМИДДОРЖ

**АКТ**  
**ЗӨВШӨӨРСӨН:**  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
Б.БААТАРЗОРИГ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Л.САНЖРАГЧАА  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
Н.БОЛОРТУЯА

Акт, албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 04 дугаар сарын 24

№ 01/217

Улаанбаатар хот

САН-2020/16/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасан цаглабарт хугацаанд хийсэн Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Уулзалтын зардал, түрээсийн төлбөрт 12.1 сая төгрөгийг зарцуулсан боловч тушаал шийдвэр төсөвгүй анхан шатны баримтын бүрдэлгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийхгүй байх, дотоод хяналтыг сайжруулах;
2. Биелэлтийг 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн ажлын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Санжрагчаа, Ерөнхий нягтлан бодогч Н.Болортуяа нарт хариуцуулав.

**ТОГТООСОН:**  
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТОР Д.ЦЭГМИДДОРЖ

**АЛБАН ШААРДЛАГА**

**ЗӨВШӨӨРСӨН:**  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
Б.БААТАРЗОРИГ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Л.САНЖРАГЧАА  
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ  
Н.БОЛОРТУЯА

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



